

судлах хамгаалах төв нь Heather Henson болон Монголын драмын театргаар хамтран зургаадугаар сарын 22 өдөр тус театрт асрамжийн газрын 100 хүүхэд болон бусад хүүхдүүд, эцэг эхчүүдэд “Тогоруу ба нар” сэдэвт утсан хүүхэлдэйн тоглолтыг толилуулсанаас гадна Монгол орны тогоруу, хамгааллын талаар танин мэдэхүйн мэдээллийг хуран цугларсан хүмүүст хүргэлээ. Ийнхүү анх удаагийнх гэхэд олон арга хэмжээ, баяр наадам, тоглолтууд, мэдээллүүдийг олон хүмүүст хүргэсэн өргөн дэлгэр Тогорууны баяр болж өнгөрлөө.

*И.Сарангэрэл, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв*

### **Монголын шувуу ажиглагчдын клуб**

Монголын шувуу ажиглагчдын клуб (МШАК) нь Монголынхоо ард иргэд, залуучууд, хvхэд багачуудад шувуудыг таниулах, байгаль дахь ач холбогдлыг нь ойлгуулах, шувуу ажиглагч, сонирхогчдын тоог өсгөх зорилгоор Зэрлэг амьтан судлах хамгаалах төвийн дэргэд 2008 оны хавар байгуулагдсан. Өнгөрсөн хугацаанд клубээс хүүхэд залуусын дунд олон арга хэмжээ зохион байгууллаа. Бид дунд сургуулийн сурагчдад зориулан «Хврээлэн буй орчин ба шувууд», «Шувуудаа таньж мэдэхийн ач холбогдол», «Шувуу хэрхэн ажиглах вэ?» «Шувууд ба багачууд» зэрэг сэдвүүдээр илтгэл, семинар, өдөрлөг зохион байгуулдаг. Мөн Дэлхийн нүүдлийн шувуудын өдрийг сүүлийн 3 жил тогтмол зохион байгуулж байна.

МШАК нь гишүүнчлэлтэй (нээлттэй, үнэ төлбөргүй) бөгөөд клубын Facebook group одоогоор 1600 гаруй гишүүнтэй болж байгаль хамгаалал болон Монгол орны шувуудын талаарх мэдлэг мэдээллийг ард түмэнд тогтмол хүргэж, мөн энэ группээрээ дамжуулан жил бүр Монголын шувуу ажиглагч, сонирхогчдын уулзалтыг зохион байгуулж байна. Саяхан буюу 2014 оны хавар Өмнөговь аймгийн төв дээр манай клубын хөдөө орон нутаг дахь анхны салбар нээгдлээ.

МШАК блог хуудсандаа өөрсдийн зохион байгуулж буй ажлуудаас байнга нийтлэж олон нийтэд хүргэхээс гадна гишүүдийнхээ шувуу ажигласан аяллын тэмдэглэлүүдийг нийтлэдэг. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай блогод үзнэ үү: <http://www.mongolbirdwatchclub.blogspot.com/>.

Клубын блог дээр 2008 оноос хойш Монгол орны шувуудын талаар болон өөрсдийн хийж буй ажлын талаар нийтдээ 150 гаруй нийтлэл тавигдсан ба манай клубын блог руу хандсан хандалтын тоо 2014 оны 11 сарын байдлаар 30.204 (нийт 81 орноос хандалт хийгджээ) хүрсэн байна.



Клубээс гишүүддээ хандан шувуу ажиглах аяллыг хот орчимд тогтмол зохион байгуулахаас гадна, Зэрлэг амьтан судлах хамгаалах төвтэй хамтран 2010 оноос эхлэн жил бүр “Монгол орны жигүүртэн амьтад” гэрэл зургийн уралдааныг уламжлал болгон зохион байгуулж байна. Энэхүү гэрэл зургийн уралдаанд Монгол оронд авсан олон сайхан шувуудын зургууд ирдэг. Эдгээр үзэсгэлэнт шувуудын зургуудаа өөрсдийн Facebook хуудсаар нийтэлж бусад хүргэхээс гадна Байгаль орчин ногоон хөгжлийн яамны хананд байршуулж олны хүртээл болгож байгаа. МШАК энэ оноос эхлэн Таван Богд группын Улаанбаатар принт ХХК-аас сурагчидад зориулан хэвлэн гаргадаг “Мэдлэгтэй дэвтэр” бүтээл дээр нь хамтран ажиллахаар болж байгаа ба ингэснээр Монгол орны шувуудын зураг болон тэдгээрийн тухай мэдээллийг сурагчид, бага насны хүүхдүүдэд шууд хүргэх боломжтой боллоо.

*П.Ганхуяг, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв*

### **Монгол орны шувуудын фото зураг – шинэ вэб сайт нээгдлээ!**

Монголд шувуу ажиглагч, сонирхогчид, мөн үзэсгэлэнт шувуудын зургийг дарах сонирхолтой гэрэл зурагчдын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр Монгол орны шувуудын зураг сүүлийн жилүүдэд ихээр хуримтлагдаж байна. Үүний нэгээхэн тод жишээ нь Зэрлэг амьтан судлах хамгаалах төв болон Монголын